

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ-НИЙГМИЙН БАЙДЛЫН 2015 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

2015.07.10

Алтай хот

Мал тооллого: Хагас жилийн мал тооллогыг сумууд бие даан явуулж тооллогын эцсийн нэгдсэн дүнгээр бүгд 3 сая 394.6 мянган мал тоологдсоны дотор тэмээ 36.7, адуу 92.8, үхэр 62.4, хонь 1 сая 64.1, ямаа 2 сая 138.4 мянган толгой мал тус тус байна. Үүнээс төллөх насны хээлтэгч бүгд 1 сая 376.0, ингэ 12.1, гүү 25.8, үнээ 23.4, эм хонь 472.8, эм ямаа 871.9 мянган толгой тоологдлоо.

Төл бойжилт: Аймгийн дүнгээр 945.4 мянган толгой буюу төллөх насны хээлтэгчийн 90.3 хувь төллөж, 929.1 мянган төл 98.2 хувиар бойжиж байна. Оны эхний төллөх насны ингэний 47.6, гүүний 78.1, үнээний 79.1, эм хонины 93.1, эм ямааны 90.3 хувь тус тус төллөж, 100 эхээс ботго 46, унага 76, тугал 77, хурга 92, ишиг 89-ийг бойжууллаа. Гарсан төлөө Дэлгэр, Хөхморьт, Чандмань, Есөнбулаг сумд 99.0-100.0 хувиар тус тус бойжуулж, харин Баян-Уул, Төгрөг, Шарга сумд төлийн хорогдлын 33.0 хувийг эзэлж байна.

Мал онд оролт: Аймгийн мал сүрэг 99.6 хувиар онд орж, бүгд 9.4 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх мөн үеэс 2.8 дахин бага байна. Бигэр, Эрдэнэ, Жаргалан, Алтай, Цогт сумд 0.85-0.55 хувиар малаа хорогдуулсан нь нийт хорогдлын 48.7 хувийг эзэлж байгаа ба бусад сумууд малаа 99.99-99.53 хувиар онд оруулжээ.

Хээл хаялт, сувайралт: Аймгийн төллөх насны хээлтэгчийн 2.0 хувь буюу 21.1 мянган хээлтэгч хээл хаяж, мөн хээлтэгчийн 5.5 хувь буюу 57.1 мянга нь сувайрсан байна Дэлгэр, Бугат, Тайшир сумд хээл хаялт багатай, Цогт, Жаргалан, Шарга сумд хээл хаялт их байна. Бугат, Чандмань, Тонхил сумдад сувайралт бага, Баян-Уул, Жаргалан, Цээл сумдад сувайралт их байна. Энэ онд хээл хаяж сувайрсан шалтгаанаар нийт хээлтэгчийн 7.5 хувь буюу 78.2 мянган хээлтэгчээс төл авч чадсангүй.

Тариалалт: Үр тариа 329.6 га, төмс 84.1 га, хүнсний ногоо 77.9 га, эмийн ургамал 130 га, жимс, жимсгэнэ 44.6 га, малын тэжээл 398.0 га, нийт 1064.2 га-д тариалалт хийлээ. Өнгөрсөн оноос тариалсан талбай бүх төрөл дээр буурчээ.

Хилийн худалдаа: 3 удаа хилийн худалдаа хийгдэж 35.5 сая ам долларын төмрийн хүдрийн баяжмал гаргаж, цемент, тоосго болон бусад тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл зэрэг 0.8 сая ам долларын бараа материал оруулж ирэв.

Үнэ: Малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ түүвэр судалгаанд сонгогдсон Алтай хотод сарын эцэст доорхи ханштай байлаа.

Сарууд	I	II	III	VI	V	VI
1 кг ноолуурын үнэ /мянган төгрөг/	40.0	40.0	50.0	30.0	49.0	53.0

Аймгийн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс түүвэр судалгаанд хамрагдсан Алтай хотод суурь оноос 56.4, өмнөх оны мөн үеэс 7.7, жилийн эцсээс 7.3, өмнөх сараас 0.6 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэр: Тайлант хугацаанд Алтай-Улиастай Эрчим хүчний систем, Мандал голомт, Тулга-Алтай, Ентүм, Ундрам-оюу, Шимт дээж, Ундарга-Алтай, Баярт олон, Залуур-Алтай, Даянтайшир, Ариун өргөө, Айргийн хад, Дуурсах-Алтай зэрэг 49 аж ахуйн нэгж, 73 хувиараа үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаа явууллаа.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл оны үнээр, 6 тэрбум 216.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 569.4 сая төгрөг буюу 10.0 хувиар өсчээ. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 12.5 сая төгрөг буюу 2.4 хувиар буурч, боловсруулах аж үйлдвэрийнх 184.5

сая төгрөг буюу 30.1 хувиар, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 397.4 сая төгрөг буюу 8.8 хувиар өслөө.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеийнхээс амтат ус, ундаа, арвайн гурил, талх нарийн боов, цахилгаан эрчим хүч, түгээсэн цэвэр ус, сувагжуулалт, гутал ботинк үйлдвэрлэл 1.2-15 дахин өсч, нүүрс, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, хиаман төрлийн бүтээгдэхүүн, хуванцар цонх үйлдвэрлэл

11.6-65.4 хувиар буусан байна.

Аж үйлвэрийн бүтээгдэхүүн үйлвэрлэлийн 90.2 хувийг Есөнбулаг, 2.3 хувийг Дарив, 1.7 хувийг Тайшир, 1.3 хувийг Чандмана, 1.1 хувийг Эрдэнэ, 0.5 хувийг Цээл сумд эзлэж байгаа нь эдгээр сумдад үйлдвэрлэл илүү хөгжиж байгааг харуулж байгаа ба үлдсэн 2.9 хувийг бусад сумд эзлэж байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 5 тэрбум 319.1 сая төгрөг болж, нийт бүтээгдэхүүн үйлвэрлэлийн 85.6 хувийг борлуулжээ.

Барилга: Эхний хагас жилийн байдлаар барилга угсралт, их засвар 5 тэрбум 952.1 сая төгрөгийн ажил хийж, үүнээс 5 тэрбум 716.4 сая төгрөгийн шинэ барилга, 235.7 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

Төсвийн орлого: Орон нутгийн төсөвт 2 тэрбум 209.4 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 98.0 хувиар биелүүлсэн байна. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөөг Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Тайшир, Төгрөг, Цээл сумууд 1-4 дахин давуулан биелүүлж, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт, Чандмань, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг сумууд төлөвлөгөөг 6.6-69.3 хувиар тасалсан байна.

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтын 77.9 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшлын төлөвлөгөөний 93.0 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн 88.6 хувь, бараа үйлчилгээний бусад зардлын 60.3 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Банкны мөнгөн орлого, зарлага: Бүгд 16 тэрбум 704.0 сая төгрөгийн зузаатгал хийж кассын гүйлгээнээс 187 тэрбум 179.0 сая төгрөг татаж, монгол банкинд 17 тэрбум 517.0 сая төгрөг шилжүүлж, гүйлгээнд 186 тэрбум 493.9 сая төгрөг гаргалаа. Зээлийн өрийн бүх үлдэгдэл 75 тэрбум 988.3 сая төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 0.06 хувийг эзэлж байна. Иргэдийн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 15.7 хувиар нэмэгджээ.

Эрүүл мэнд: Эхний хагас жилийн байдлаар 643 эх амаржиж, 648 хүүхэд мэнд төрлөө. Одоогоор аймгийн хэмжээнд эмнэлгийн хяналтанд авагдсан 621 жирэмсэн эхчүүд байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 8 тохиолдол бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 246 халдварт өвчний өвчлөл дотроос гепатит 3.7, бэлгийн замын халдварт өвчнүүд 69.5, сүрьеэ 6.1, улаан бурхан 10.2 хувийг тус тус эзэлж байна. Хорт хавдараар өвчилсөн 70 тохиолдол шинээр бүртгэгдсэн ба энэ өвчнөөр нас барсан 43, осол гэмтлээр нас барсан 15 тохиолдол бүртгэгдлээ. Тайлант онд эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд давхардсан тоогоор 114.4 мянган хүнд үзлэг хийж, 7.6 мянган хүнийг хэвтүүлэн эмчилж, 57.7 мянган ор хоног ашиглажээ.

Аудитын газар: Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг 322 байгууллагын 258 санхүүгийн тайланд, гүйцэтгэлийн аудит 4, нийцлийн аудит 2 байгууллагад тус тус хийжээ. Санхүүгийн тайланд аудит хийсэн дүнгээс үзэхэд 113 санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, 103 санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт, 10 санхүүгийн тайланд сөрөг санал дүгнэлт, 1 санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан санал дүгнэлт өглөө. Өмнөх оноос аудитын тоо 33-аар буурсан бол зөрчилгүй дүгнэлтийн тоо 95-аар буурч, хязгаарлалттай дүгнэлтийн тоо 27-оор, сөрөг дүгнэлтийн тоо 3-аар, дүгнэлт өгөхөөс татгалзсан санал дүгнэлтийн тоо 1-ээр тус тус өссөн байна.

Аудитаар 17900.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 2581.6 сая төгрөгийг залруулж, 9851.2 сая төгрөгийн зөрчилд 418 заалт бүхий албан шаардлага, 76 заалт бүхий зөвлөмж өгч, 898.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосоноос өмнөх оноос шилжиж ирсэн актыг оролцуулан 483.7 сая төгрөгийн актыг барагдууллаа.

Ажлын хариуцлага алдсан 95 ажилтанд хариуцлага тооцох саналыг томилдог албан тушаалтанд хүргүүлсэнээр 48 нь хэрэгжсэн байна

Мэргэжлийн хяналтын газар: Эхний хагас жилийн байдлаар 278 хуулийн этгээд, 46 иргэнд мэргэжлийн хяналт хийж, 2516 зөрчил илрүүлсний 43.7 хувийг газар дээр нь арилгуулав. Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн зөрчилтэй үйл ажиллагааг засахад чиглэгдсэн 11 сая 20.0 мянган төгрөгийн торгууль тавьж барагдуулалт 12.9 хувьтай байна. Мөн гаргасан дүгнэлтийн 94.2, албан шаардлагын 17.1 хувийг биелүүлээд байна. Хагас жилийн байдлаар 1 байгууллагын үйл ажиллагааг бүрэн зогсоож, 2 байгууллагын үйл ажиллагааг түр зогсоожээ.

Хөдөлмөрийн хэлтэс: Эхний хагас жилийн байдлаар хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйчүүд 1175 болсны дотор 61.9 хувь буюу 727 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 334 нь дээд, 107 нь тусгай дунд, 118 мэргэжлийн анхан шатны, 487 нь бүрэн дунд, 70 нь бүрэн бус дунд, 48 нь бага, 11 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна. Тус алба тайлант хугацаанд 146 хүнийг түр болон бүр ажилд ороход нь зуучлав.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс: Хагас жилийн байдлаар 16.3 мянган хүнд 2 тэрбум 711.2 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт олгожээ.

Биеийн тамир спортын хороо: Баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 4 төрлөөр 95 тамирчин оролцсоноос хөл бөмбөгөөр мөнгө, хүрэл, жу-до бөхөөр алт, мөнгө, хүрэл, “Хөдөөгийн хүчтэн аварга шалгаруулах барилдаан”-аар алтан медаль тус тус авсан байна. Мөн нийтмийн биеийн тамирын арга хэмжээнд нийт 1256 хүн оролцжээ.

Стандарчилал, хэмжил зүйн төв: Тус хэлтэс нь төлбөртэй үйл ажиллагаанаас 5.4 сая төгрөгийн орлого олох төлөвлөгөөтэй, өөрийн нөөц бололцоогоо бүрэн дайчлан ажилласнаар 18.7 сая төгрөгийн орлого олж өөрийн орлогын төлөвлөгөөг 3.5 дахин давуулж биелүүллээ. 18 сумдад худалдаа, үйлчилгээ эрхэлж буй 25 аж ахуйн нэгж, иргэний 12 нэрийн 72 бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамрууллаа. Засгийн газрын 127-р тогтоолын 1-р хавсралтанд заасан тохирлын баталгаанд заавал хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтын дагуу аймгийн төв болон сумдын 147 хүнсний дэлгүүр, шатахуун түгээх станц 6, 4 гоо сайхан, 14 үсчин, баар, зоогийн газар 49, халуун ус 20, зочид буудал 5, 5 хүүхдийн тоглоомын газар зэрэг нийт 250 үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийснээс стандартын шаардлага хангасан 59 хүнсний дэлгүүр, баар зоогийн газар 8, хүүхдийн тоглоомын газар 3, зочид буудал 1, үсчин 1, нийт 72 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг шинээр олгох буюу хугацааг сунгалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар: Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр, Улсын хэмжээнд 1 сая мод тарьж ургуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд төв суурин газрын 176 айл өрх 814 ширхэг мод, ААНБ-ууд нийтийн эзэмшлийн талбай болон байгууллагын гадна тохижилтондоо 4288 ширхэг мод, нэрэмжит төгөл, бичил цэцэрлэгт 426 мод, шинээр нийт 7 га талбайд цэцэрлэг байгуулж 2900 мод тарьж нийт 158 ААНБ, 2874 иргэн орлцож 8511 мод, бут сөөг тарьж 2930 м2 талбайг зүлэгжүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор Улаанбаатар хотод 5 дугаар сарын 14-15 ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Байгалийн нөөцийн хамтын менежмент” нөхөрлөлүүдийн үндэсний чуулганд аймгаас 20 нөхөрлөлийн 25 төлөөлөгч оролцож, 6 нөхөрлөл суль, цулхир, малын тоног хэрэгсэл, хужир, эсгий эдлэл, ноос ноолуураар хийсэн бүтээлүүдээ сурталчилан борлууллаа.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар: Энэ онд аймгийн хэмжээнд 29.82 га газрыг 68 иргэнд гэр бүлийн хэрэгцээнд зориулан үнэгүй өмчлүүлсэн байна. Одоогийн байдлаар өссөн дүнгээр аймгийн хэмжээнд 5697 иргэнд 539.6 га газрыг өмчлүүлсэн нь нийт хүн амын 10.05 хувийг эзэлж байна. Мөн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж авсан 21 өрхийн гэр бүлийн хэлцлийг үндэслэн 21 иргэнд өмчлүүлж, 57 иргэний шинээр газар өмчилж авах эрхийг үүсгэжээ.

Ерөнхий боловсролын сургуулиуд: Ерөнхий боловсролын 28 сургууль, 27 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Эдгээр сургуулиудад 11.7 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.3 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд тавдугаар ангийг 950, есдүгээр ангийг 1252, арван хоёрдугаар ангийг 670 хүүхэд төгсгөлөө

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Энэ хичээлийн жилд 1017 суралцагчид сурч, нийт 79 ажиллагсад, мэргэжлийн 35, ерөнхий боловсролын 13 багштай ажиллаж байна. 2014-2015 оны хичээлийн жилд 12 мэргэжлээр 257 хүүхэд төгсжээ.

Тэгш-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 53 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Батлан Хамгаалахад туслах Нийгэмлэг: Авто машины жолоочийн дамжаагаар 17 хүнийг “В,С” ангиллаар жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Ихэс-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 8 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Авто тээвэр: Зорчигч, ачаа тээврээр байгууллага иргэдэд үйлчилж 337.1 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Нефть хангамжийн бааз: 1 тэрбум 728.0 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалыг татан авч 2 тэрбум 524.8 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалын борлуулалт хийлээ.

Цахилгаан холбоо компани: Суурин телефон цэгийн тоо 799, холбоо ашиглалтын орлого 145.0 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 101.5 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний 2 цэг 19-н суудалтай ажиллаж интернетээр дунджаар 6.7 мянган хүнд үйлчилжээ.

Шуудан үйлчилгээний газар: Сум, хот, хооронд шуудан, хэвлэл захиалга, илгээмж, зорчигч тээвэр үйлчилж бүгд 17.7 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Мобиком корпорацийн Говь-Алтай дахь салбар: Тус салбар энэ оны эхний хагас жилийн байдлаар үндсэн хэрэглэгч 1.0 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 22.2 мянга, бүгд 23.2 мянган хэрэглэгчтэй байна.

Юнител ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь үндсэн хэрэглэгч 0.8 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 19.6 мянга, бүгд 20.4 мянган хэрэглэгчтэй байна.

Ж-Мобайл ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь дараа төлбөрт 0.9 мянга, урьдчилсан төлбөрт 24.0 мянган хэрэглэгчтэй болоод байна.

Миний нутаг телевиз: Мэдээ, сонины тоймыг 66 цаг, хүүхэлдэйн болон уран сайхны киног 675 цаг, зар сурталчилгааг 9 цаг, захиалгат болон шууд нэвтрүүлгийг 9 цаг цацан гаргасан байна.

Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс: Хүүхэд хөгжүүлэх бүжиг, гоо зүй, амьдрах ухаан, зураг урлал, дизайн, англи хэлний дугуйлангуудад нийт 209 хүүхэд хамрагдан суралцаж байна. Тус хэлтсээс санаачлан Ардын дуу бүжгийн Алтай чуулга, Боловсрол соёлын газар, Дэлгэр, Халиун, Тонхил, Есөнбулаг сумын ЗДТГ, ЕБС-ийн сургууль, соёлын төвүүд дэмжин хамтарч Баруун Монгол, тэр дундаа Алтай нутгийн мартагдан бүдгэрч буй ардын урлагийн төрлүүдийг сэргээн хойч үед өвлүүлэх, ирээдүйн авьяаслаг уран бүтээлчид, өв соёлоо тээгчдийг бэлтгэх, нээн илрүүлэх зорилгоор “Алтай алтан өв” өв соёл, хүүхдийн урлагийн их наадмын III шатыг 5 сарын 2-ны өдөр АДБ-ийн Алтай чуулгад зохион байгууллаа. Уг наадамд 4 бүсээс шалгарсан авьяаслаг 169 хүүхэд 14 төрлөөр оролцож авьяас чадвараа сорилоо.

Ардын дуу Бүжгийн “Алтай” чуулга: Нийт 33 удаагийн тоглолт хийж 5.4 мянган үзэгчид үзжээ. Нийт 4.7 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Аймгийн музей: Онцгой болон түүх дурсгал, эд өлгийн 2.5 мянган үзвэрээр 1.8 мянган үзэгчдэд үйлчилж 1.7 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Аймгийн номын сан: Эхний хагас жилд шинээр 721 уншигч бүртгэж 7.9 мянган уншигчдад 25 төрлийн тогтмол хэвлэл, 10.9 мянган номоор үйлчилжээ.

Онцгой байдлын хэлтэс: Галын дуудлаганд 14 удаа гарч, 4.1 мянган айл өрх, 100 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж зөвөлгөө өгч, 63.3 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварчээ. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалж гал түймрийн улмаас 14.9 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа. Хагас жилийн байдлаар 14 удаагийн гал түймэр гарсны 10-ыг нь онцгой байдлын хэлтэс, үлдсэн 4-н түймрийг иргэд өөрсдөө унтраасан байна.

Гамшгийн мэдээ: Онцгой байдлын эрэн хайх, аврах бүлэг галзуу өвчний 23, салхи шуурганы аюулт үзэгдлийн 7, үерийн аюулт үзэгдлийн 4, аянганы аюулт үзэгдлийн 2 удаагийн дуудлага тус тус хүлээн авч ажилласан байна.

Гэмт хэрэг: Эхний хагас жилд байгууллага иргэдийн 122.1 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 118 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс хулгайн гэмт хэрэг, үүнээс орон байрны хулгай, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргүүд дийлэнх хувийг эзэлж байна. Гарсан нийт хэргийн 62.7 хувь нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна.

Баривчлагдсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 32 хүн буюу 23.8 хувиар, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүний тоо өмнөх онтой харьцуулахад 8 хүн буюу 4.6 хувиар буурсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба: Энэ онд 132 гүйцэтгэх хуудасны хоёр тэрбум 183.5 сая төгрөгийн төлбөрт шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулж үүнээс 57 гүйцэтгэх хуудасны 18.5 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор биелүүлсэн байна. Мөн 33 тэтгэлэг төлөгчөөс 8.8 сая төгрөгийн тэтгэлгийг хэсэгчлэн гаргуулсан байна.

Хорих ялтай ялтны 12 гүйцэтгэх хуудасны 26.2 сая төгрөгийн төлбөр хохирол гаргуулахаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулж, хорих ангиудад суутгалын бичиг явуулан 3 гүйцэтгэх хуудасны 779.6 мянган төгрөгийг биелүүлсэн байна.

Сум	Бэлэн тоологдсон мал						үүнээс: хээлтээгч					
	Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Бүгд	ингэ	гүү	үнээ	ЭМ ХОНЬ	ЭМ ЯМАА
1.Алтай	98626	2334	1797	1503	16212	76780	39869	649	436	528	6764	31492
2.Баян-Уул	229459	1732	7605	4518	86481	129123	83273	453	1937	1473	33649	45761
3.Бигэр	170039	1902	4640	5717	42146	115634	61792	591	1219	1837	17142	41003
4.Бугат	132811	1236	2919	1456	41853	85347	43497	312	739	449	14011	27986
5.Дарив	200459	1626	7147	3903	75830	111953	85410	514	1780	1481	33372	48263
6.Дэлгэр	298420	2074	6642	4314	105773	179617	99995	561	1762	1598	36428	59646
7.Жаргалан	158786	861	3415	3372	55791	95347	68772	263	722	1200	27425	39162
8.Тайшир	118165	492	3248	2198	43247	68980	40790	74	672	500	14674	24870
9.Тонхил	236189	373	8267	3382	114252	109915	88707	84	2481	1115	44307	40720
10.Төгрөг	153364	5224	5500	2286	52411	87943	52972	1811	1158	658	19021	30324
11.Халиун	241346	3434	6391	5672	71569	154280	102072	1038	1691	2143	31780	65420
12.Хөхморьт	140848	2642	8838	4212	47566	77590	52321	566	2025	1314	18699	29717
13.Цогт	250459	2510	3422	4383	68069	172075	207298	2304	3298	3773	54787	143136
14.Цээл	193761	1453	4833	3557	43615	140303	76999	438	1400	1238	17645	56278
15.Чандмань	176760	1022	4079	2062	59689	109908	55577	123	765	269	19354	35066
16.Шарга	161954	5009	4929	4830	31659	115527	65778	1619	1472	1890	12879	47918
17.Эрдэнэ	228908	1833	2751	878	41512	181934	66803	468	647	236	12679	52773
18.Есөнбулаг	204251	924	6354	4397	66411	126165	84098	286	1601	1661	28156	52394
ДҮН	3394605	36681	92777	62640	1064086	2138421	1376023	12154	25805	23363	442772	871929
6/30/2014	2900099	35045	77667	50518	901086	1835783	1082928	10131	19265	16439	352352	684741

REARING OF YOUNG ANIMALS

2015.07.06

Сум	Soums	Төллөсөн хээлтээч						Хорогдсон төл					
		BREEDING STOCK						LOSSES OF YOUNG ANIMALS					
		Бүгд	инээ	гүү	үнээ	эм хонь	эм ямаа	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ушиг
Total	female camel	mare	cow	ewe	female goat	total	female camel	mare	cow	ewe	female goat		
1. Алтай	Altai	25844	318	251	300	4521	20454	497	25	15	19	133	305
2. Баян-Уул	Bayan-Uul	56303	208	1350	989	22869	30887	2301	6	50	20	663	1562
3. Бигэр	Biger	43966	253	807	1271	11274	30361	1175	13	19	22	465	656
4. Бугат	Bugat	40104	147	645	403	13009	25900	641	8	17	17	110	489
5. Дарив	Dariv	57523	218	1256	890	22603	32556	756	9	48	25	271	403
6. Дэлгэр	Delger	84184	284	1296	1018	30787	50799	233	0	2	5	67	159
7. Жаргалан	Jargalan	40271	136	523	702	15253	23657	803	2	4	10	259	528
8. Тайшир	Taishir	34781	66	502	507	13091	20615	772	3	12	9	192	556
9. Тонхил	Tonhil	69927	38	1752	851	35501	31785	750	11	108	51	191	389
10. Төгрөг	Tugrug	45435	742	1082	606	16594	26411	1837	2	33	33	501	1268
11. Халиун	Haliun	66452	469	989	1365	21906	41723	962	6	12	20	305	619
12. Хөхморьт	Huhmorit	39452	252	1623	1028	14149	22400	0	0	0	0	0	0
13. Цогт	Tsogt	69935	327	677	1157	18748	49026	1604	2	30	25	139	1408
14. Цээл	Tseel	52514	141	925	801	12519	38128	643	2	39	20	84	498
15. Чандмань	Chandmani	51467	136	875	523	18032	31901	355	0	0	0	123	232
16. Шарга	Sharga	43382	860	861	1061	9295	31305	1505	15	66	68	220	1136
17. Эрдэнэ	Erdene	64557	250	530	214	12448	51115	1683	14	12	9	401	1247
18. Есөнбулаг	Yesunbulag	59336	113	1248	1164	20018	36793	588	0	24	34	219	311

ДҮН	Total	945433	4958	17192	14850	312617	595816	17105	118	491	387	4343	11766
6/30/2014	Previous year	831492	4837	14173	12313	269691	530478	23013	141	383	306	5426	16757

Сум	Soums	Бойжсон төл						Бойжилтын хувь					
		Young surviving animals						Survival percentage					
		Бүгд	ботго	унага	тугал	хурга	ушиг	Бүгд	ботго	унага	тугал	хурга	ушиг
Total	colt	foals	calves	lambs	kids	Total	colt	foals	calves	lambs	kids		
1. Алтай	Altai	25347	293	236	281	4388	20149	98.1	92.1	94.0	93.7	97.1	98.5
2. Баян-Уул	Bayan-Uul	54002	202	1300	969	22206	29325	95.9	97.1	96.3	98.0	97.1	94.9
3. Бигэр	Biger	42791	240	788	1249	10809	29705	97.3	94.9	97.6	98.3	95.9	97.8
4. Бугат	Bugat	39463	139	628	386	12899	25411	98.4	94.6	97.4	95.8	99.2	98.1
5. Дарив	Dariv	56777	209	1208	865	22337	32158	98.7	95.9	96.2	97.2	98.8	98.8
6. Дэлгэр	Delger	83951	284	1294	1013	30720	50640	99.7	100.0	99.8	99.5	99.8	99.7
7. Жаргалан	Jargalan	39790	134	519	693	15072	23372	98.0	98.5	99.2	98.6	98.3	97.8
8. Тайшир	Taishir	34407	63	490	498	13049	20307	97.8	95.5	97.6	98.2	98.5	97.3
9. Тонхил	Tonhil	69177	27	1644	800	35310	31396	98.9	71.1	93.8	94.0	99.5	98.8
10. Төгрөг	Tugrug	43598	740	1049	573	16093	25143	96.0	99.7	97.0	94.6	97.0	95.2
11. Халиун	Haliun	65490	463	977	1345	21601	41104	98.6	98.7	98.8	98.5	98.6	98.5
12. Хөхморьт	Huhmorit	39452	252	1623	1028	14149	22400	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
13. Цогт	Tsogt	68331	325	647	1132	18609	47618	97.7	99.4	95.6	97.8	99.3	97.1
14. Цээл	Tseel	51871	139	886	781	12435	37630	98.8	98.6	95.8	97.5	99.3	98.7
15. Чандмань	Chandmani	51112	136	875	523	17909	31669	99.3	100.0	100.0	100.0	99.3	99.3
16. Шарга	Sharga	41877	845	795	993	9075	30169	96.5	98.3	92.3	93.6	97.6	96.4
17. Эрдэнэ	Erdene	62874	236	518	205	12047	49868	97.4	94.4	97.7	95.8	96.8	97.6
18. Есөнбулаг	Yesunbulag	58748	113	1224	1130	19799	36482	99.0	100.0	98.1	97.1	98.9	99.2

ДҮН	Total	929058	4840	16701	14464	308507	584546	98.2	97.6	97.1	97.4	98.6	98.0
6/30/2014	Previous year	808479	4696	13790	12007	264265	513721	97.2	97.1	97.3	97.5	98.0	96.8

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДЛЫН МЭДЭЭ

LOSSES OF ADULT ANIMALS

Сум	Soums	Эзлэх хувь percentage	Бүгд хорогдол losses						Бүгдээс өвчнөөр хорогдсон Disaster losses						Бүгдээс хорогдсон хээл Losses of breeding stock				
			Бүгд Total	тэмээcamel	адуу horse	үхэр cattle	хонь sheep	ямаа goat	Бүгд Total	тэмээcamel	адуу horse	үхэр cattle	хонь sheep	ямаа goat	Бүгд Total	тэмээ camel	адуу horse	үхэр cattle	хо she
Алтай	Altai	0.56	420	20	25	24	140	211	0	0	0	0	0	0	173	8	7	10	
Баян-Уул	Bayan-Uul	0.47	866	7	24	12	164	659	38	3	3	2	10	20	200	2	4	1	
Бигэр	Biger	0.85	1130	14	50	47	351	668	185	3	12	4	63	103	334	3	13	13	1
Бугат	Bugat	0.35	343	2	11	4	58	268	240	2	2	3	41	192	166	0	3	0	
Дарив	Dariv	0.45	664	7	19	33	123	482	6	1	0	0	2	3	93	1	2	14	
Дэлгэр	Delger	0.05	104	0	2	10	28	64	15	0	1	2	4	8	25	0	0	3	
Жаргалан	Jargalan	0.61	755	2	5	6	314	428	53	1	0	0	23	29	190	1	1	2	
Тайшир	Taishir	0.13	113	0	2	3	40	68	21	0	1	2	10	8	51	0	0	2	
Тонхил	Tonhil	0.39	671	0	42	19	310	300	0	0	0	0	0	0	78	0	1	0	
Төгрөг	Tugrug	0.14	162	0	0	0	71	91	0	0	0	0	0	0	66	0	0	0	
Халиун	Haliun	0.30	548	26	19	30	155	318	59	4	3	12	16	24	190	18	7	12	
Хөхморьт	Huhmorit	0.01	16	1	11	4	0	0	16	1	11	4	0	0	0	0	0	0	
Цогт	Tsogt	0.55	1149	25	15	19	196	894	0	0	0	0	0	0	300	0	0	0	
Цээл	Tseel	0.17	244	4	8	15	60	157	97	0	0	2	28	67	30	0	0	3	
Чандмань	Chandmani	0.23	318	0	2	1	112	203	0	0	0	0	0	0	48	0	0	1	
Шарга	Sharga	0.29	354	2	21	31	120	180	0	0	0	0	0	0	135	1	8	12	
Эрдэнэ	Erdene	0.66	1145	16	37	8	216	868	64	0	0	0	28	36	422	4	8	6	1
Есөнбулаг	Yesunbulag	0.30	440	0	18	23	154	245	58	0	0	10	25	23	84	0	1	9	
ДҮН	Total	0.37	9442	126	311	289	2612	6104	852	15	33	41	250	513	2585	38	55	88	6
6/30/2014	Previous year	1.19	26518	123	372	250	5865	19908	706	12	13	25	196	460	5755	31	54	48	11

2015.07.04

Бараа/Сум	Goods/Sum	Алтай Altai	Баян-Уул Bayan-Uul	Бигэр Biger	Бугат Bugat	Дарив Dariv	Дэлгэр Delger	Жаргалан Jargalan	Тайшир Taishir	Тонхил Tonkhi	Төгрөг Tugrug	Халиун Khaluun	Хөхморьт Khuukmorit	Цогт Tsogt	Цээл Tseel	Чандмань Chandmani	Шарга Sharga	Эрдэнэ Erdene	Есөнбулаг Yesunbulag
Гурил \А.Т-1\, 1кг	Flour, grade 1, kg	1040	980	1000	1040	1100	960	1050	850	1000	1000	1040	960	1000	1000	1040	1000	1000	1200
Гурил \Орос\, 1кг	Flour, Russian, kg	1040	980	1500	1400	1100	0	0	0	1250	700	980	960	1000	1000	1000	960	1000	1000
Жигнэмэг, /Янзагатай/ дотоод	Biscuit, domestic	300	300	500	500	350	400	500	350	500	500	450	700	450	700	400	500	350	300
Цагаан будаа, /Сайн чанарын/ 1кг	Rice, /best quality/, kg	2300	2500	2500	2500	2000	2500	2500	2300	2200	2500	2200	2700	2200	2500	2500	2200	2200	2200
Шар будаа, 1кг	Millet, kg	2500	2000	2000	1800	1800	2000	2500	2000	2200	2500	2200	2500	2500	2200	2200	2200	2000	1800
Элсэн чихэр, 1кг	Sugar, kg	2000	2000	2000	2000	2000	2000	1800	2000	1800	2000	1700	2200	2000	2200	2000	2000	2100	1800
Чихэр, /Барбарис/ 1 кг	Candy, kg	7500	6000	6500	5000	5300	8000	7000	6000	7500	6500	5500	6000	6000	7000	5500	5000	5500	4500
Ногоон цай \ Мөнгөн аягатай\	Green tea, 2 kg	10000	7000	6500	7000	7800	6500	7000	6500	8000	6500	6000	7000	6500	7000	6500	6500	6000	6000
Давс \ иоджуулсан\ 1 кг	Salt, iodated, kg	1000	1000	1000	1000	700	800	900	700	1000	700	800	1000	700	800	1000	1000	1500	700
Ургамлын тос, л/Санни/ /	Vegetable oil, l	4000	3500	4000	4500	3600	4000	3700	4000	4500	3500	3500	3800	3500	4000	3800	3800	4500	3500
Архи, дотоод, 0.5 л /Ерөөл/	Alcohol, domestic, 0.5 l	10000	8500	8000	10000	8800	8000	7500	7500	9000	8000	8300	8000	7500	8000	8500	7500	7000	7500
Дүнсэн тамхи \Орос\ /	Making, Russian Match,	13000	6500	9000	7000	8000	11000	11000	7000	12000	10000	10000	11000	9500	8500	8500	7500	7500	5500
Шүдэнз \орос\ /	Russian Gauze, m	600	600	700	700	500	600	600	500	600	560	600	600	600	500	600	500	500	400
Марль 1м /	Laundry soap	1800	1000	1100	1000	1500	700	1200	600	800	1500	1200	2000	1500	1200	1500	1500	1000	1000
Эдийн саван /OK/ /	Washing detergent	800	700	800	800	800	800	800	700	800	800	800	800	800	800	1000	700	800	500
Угаалгын нунтаг\ОМО\400 гр ууттай	/OMO/400gr Cotton cloth /distress	2800	2500	2600	3000	3600	3000	3000	3000	3500	3500	2600	3200	2200	3500	2800	3200	3500	2500
Цоохор даавуу \Хямд\ 150 см өргөнтэй	prices/ wide 150sm	8500	4000	5000	2800	4200	0	2500	0	4500	3750	2800	3000	5000	4000	4000	4500	3000	1800
Лаа \Хятад\ /	Candle, China	700	300	350	350	350	300	400	250	200	400	400	600	350	400	400	300	500	250
Нүүр гарын саван \LUX\ /	Beauty soap, LUX	900	900	800	800	800	800	800	700	800	800	800	800	800	1200	1000	800	800	500
Шүдний оо, ш, \PS\ 130 гр том	Tooth-paste, PS, 130g big	2800	1800	1500	2000	1600	2500	1800	2000	1600	2000	1500	2000	2000	2000	2000	1500	1800	1500
Радионы зай \Хятад\ 1ш	Battery, china	800	600	800	600	500	500	800	500	800	600	700	800	1000	500	500	600	500	300
Янжуур \ Улаан шонхор\ /	Cigarette, Ulaan shonkhor	2200	1800	2000	2000	1700	2000	1750	1800	1800	1800	2000	1700	1800	1800	2000	2000	1600	1700
Бензин, АИ-80, 1л /	Petrol "AI-80" litre	1850	1800	1800	1820	1820	1800	1750	1750	1800	1820	1800	1720	1870	1840	1820	1690	1820	1690
Сумаас аймаг орох нэг талын зардал	Cost of travel	30000	10000	10000	18000	18000	5000	12000	4000	18000	12000	10000	17000	25000	18000	20000	7000	20000	0
Цахилгаан задгай, /	Electricity,	120	113	90	120	110	110	110	110	113.9	110	110	94.1	110	124.2	114	124.2	100	94.1

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, нэр төрлийн ангиллаар
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

ОРЛОГЫН ТӨРӨЛ	INCOME TYPE	мян.төг / tous.tog		
		Төлөвлөгөө Project	Гүйцэтгэл Performance	Хувь Rate
ОРОН НУТГИЙН ОРЛОГО		21,862,350.6	26,044,339.8	119.1
ТАТВАРЫН ОРЛОГО		2,254,580.9	2,209,431.2	98.0
Орлогын албан татвар		1,675,261.3	1,723,491.2	102.9
Хувь хүний орлогын албан татвар		2,271,528.3	2,249,732.5	99.0
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		2,141,792.1	2,069,517.0	96.6
Үйл ажиллагааны орлого		37,599.6	87,486.3	232.7
Хөрөнгө борлуулсны орлого		49,800.0	54,273.6	109.0
Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал		0.0	5,132.1	0.0
Шууд бус орлого		42,336.6	33,273.3	78.6
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-600,000.0	-528,060.0	88.0
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлого		3,733.0	1,818.7	48.7
Хөрөнгийн албан татвар		301,757.9	273,605.0	90.7
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		140,071.9	71,180.7	50.8
Бууны албан татвар		3,958.0	2,220.5	56.1
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар		157,728.0	200,203.8	126.9
Бусад татвар, төлбөр, хураамж		277,561.7	212,335.1	76.5
Бусад нийтлэг төлбөр, хураамж		150,239.8	137,849.4	91.8
Улсын тэмдэгийн хураамж		56,192.6	62,555.6	111.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		10,671.0	24,823.7	2 дахин
Хог хаягдлын үйлчилгээний хураамж		83,376.2	45,344.3	54.4
Бусад татвар		0.0	5,125.8	0.0
Газрын төлбөр		71,369.9	41,569.6	58.2
Газрын төлбөр		41,369.9	41,569.6	100.5
Дуудлага худалдаа		30,000.0	0.0	0.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр		55,802.0	32,224.2	57.7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		0.0	3,280.6	0.0
Ойн нөөц ашигласны төлбөр		750.0	841.4	112.2
